



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 2/17

Жаргалтхаан сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Тал нутгийн тансаг агаар” цас мөсний баярыг зохион байгуулахад 824.000 (найман зуун хорин дөрвөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд зарцуулагдах 824.000 (найман зуун хорин дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр , нягтлан бодогч Т.Энхсайхан нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ГАНБАТ